



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: 6226 3168, Факс: (976-11) 312 315,
E-mail: info@mrt.gov.mn, http://www.mrt.gov.mn


2016.04.13 № 08/1527
танай 2016.03.30 ны № 04/926 -т

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Г.НЯМДАВАА ТАНАА**

Зам тээврийн сайдын 2016 оны “Ашиглалтын өмнөх удирдах хорооны бүрэлдэхүүнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 87 дугаар тушаалыг хүргүүлэв.

Улаанбаатар хотын Олон Улсын онгоцны шинэ буудлын барилгын ажил 9 сарын дараа ашиглалтад орох тул ашиглалтын бэлтгэл ажлыг бүрэн хангах, нисэх буудлын ашиглалтын өмнөх үйл ажиллагааг нэгтгэх, удирдан зохион байгуулах үйл явцыг эрчимжүүлэх тал дээр анхаарч ажиллана уу.

Хувийг: Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих Төслийн нэгжийн захирал Н.Энхбатад.

АГААРЫН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ХЭЛТСИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  С.МӨНХНАСАН





МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2016 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 87

Улаанбаатар хот

Ашиглалтын өмнөх удирдах хорооны
бүрэлдэхүүнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1.Зам, тээврийн сайдын 2015 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн "Ашиглалтын өмнөх удирдах хороо байгуулах тухай" 32 дугаар тушаалын 1 дэх заалтын нарийн бичгийн дарга "Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих Төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирал" гэснийг "Чингис хаан Олон улсын нисэх буудлын захирал" гэж, гишүүн "Иргэний нисэхийн ерөнхий газрын Нисэх буудлуудын удирдах газрын ахлах мэргэжилтэн" гэснийг "Иргэний нисэхийн ерөнхий газрын "Нисэх буудлуудын удирдах газрын менежер" гэж тус тус өөрчилсүгэй.

2.Мөн тушаалын 1 дэх заалтын "Ашиглалтын өмнөх удирдах хороо"-ны гишүүнд "Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирал", "Улаанбаатар хотын шинэ нисэх буудлын Агаарын навигацийн үйлчилгээний бэлтгэл ажлын хэсгийн дарга" гэж тус тус нэмсүгэй.

САЙД

